

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/224/НА-СТА-ОНӨААТҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Архангай аймаг 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	12
8.1 Албан шаардлага	12
8.2 Зөвлөмж	12
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	<u>13</u>

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022 о. 03. 15 № 157
танай _____ -ны № _____ -т
Аудитын санал дүгнэлт

“ЦӨМ СҮРГИЙН ҮРЖЛИЙН ТӨВ”
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ё.ДЭЛГЭРЦОГТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн дүнг эс тооцвол “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь сар бүр цалингийн тооцооны данс, бүртгэл хөтөлж, цалингийн цэс буюу анхан шатны баримт бүрдүүлээгүй, жилийн эцэст 9.3 сая төгрөгөөр нэг удаа бүртгэж тайлагнасан, бараа материал худалдан авсан 1.9 сая төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгүүлж баталгаажуулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 2.2 сая төгрөгийг бодитой илэрхийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4 “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” гэж заасан болон Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга

бэлтгэх заавар"-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,850,608.92	94,593,577.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,865,850.52	416,569.56
31100	Кассад байгаа бэлэн мөнгө	1,262.73	1,262.73
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	2,864,587.79	415,306.83
35	БАРАА МАТЕРИАЛ	5,964,758.40	6,464,758.40
35400	Хангамжийн материал	5,964,758.40	6,464,758.40
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	86,020,000.00	87,712,250.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	86,020,000.00	87,712,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	179,029,941.00	180,101,581.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	179,029,941.00	180,101,581.00
39200	Биет хөрөнгө	2,822,865.00	2,202,255.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,286,850.00	1,286,850.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-643,425.00	-900,795.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,632,400.00	3,632,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,452,960.00	-1,816,200.00
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	176,207,076.00	177,899,326.00
39401	Биологийн хөрөнгө /ТӨҮГ/	176,207,076.00	177,899,326.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	273,880,549.92	274,695,158.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,374,117.63	3,432,053.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,374,117.63	3,432,053.96
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	3,374,117.63	3,432,053.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	270,506,432.29	271,263,105.00
51	Засгийн газрын хувь оролцоо	270,506,432.29	271,263,105.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	236,102,883.00	236,102,883.00
51200	Хуримтлагдсан үр дүн	34,403,549.29	35,160,222.00
51210	Өмнөх үеийн үр дүн	3,598,638.82	34,403,549.29
51220	Тайлант үеийн үр дүн	30,804,910.47	756,672.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	273,880,549.92	274,695,158.96

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	71,268,000.00	21,944,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,268,000.00	21,944,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	71,268,000.00	21,944,500.00
120009	Бусад орлого	55,978,000.00	8,264,500.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	15,290,000.00	13,680,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	40,463,089.53	21,187,827.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,463,089.53	21,187,827.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,463,089.53	21,187,827.29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,842,479.53	20,567,217.29
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	36,419,711.70	11,252,046.54
210813	Бусад зардал /ТӨҮГ/	0.00	9,231,096.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	3,422,767.83	84,074.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	620,610.00	620,610.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	620,610.00	620,610.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	30,804,910.47	756,672.71
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	30,804,910.47	756,672.71

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,102,883.00	15,773,288.82	251,876,171.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	(12,174,650.00)	(12,174,650.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,102,883.00	3,598,638.82	239,701,521.82
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	30,804,910.47	30,804,910.47
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,102,883.00	34,403,549.29	270,506,432.29
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	236,102,883.00	34,403,549.29	270,506,432.29
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	236,102,883.00	34,403,549.29	270,506,432.29
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	756,672.71	756,672.71
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	236,102,883.00	35,160,222.00	271,263,105.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	35,668,000.00	18,560,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,668,000.00	18,560,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,668,000.00	18,560,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,668,000.00	18,560,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,668,000.00	18,560,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,294,003.55	12,508,824.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,294,003.55	12,508,824.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,294,003.55	12,508,824.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,148,014.53	7,750,313.80
210106	Ажилсагчдад төлсөн /ТӨҮГ/	12,148,014.53	7,750,313.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,013,754.64	2,301,226.56
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	2,013,754.64	2,301,226.56
2104	Хангамж, бараа материалын зардал	4,700,000.00	1,970,000.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	4,700,000.00	1,970,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,432,234.38	487,284.40
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	386,820.64	487,284.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(2,626,003.55)	6,051,175.24
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	(8,500,456.20)
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	8,500,456.20
250006	Бусад зардал	0.00	8,500,456.20
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(2,626,003.55)	(2,449,280.96)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,491,854.07	2,865,850.52
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,865,850.52	416,569.56

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	мян.төг	15,290.00	16000.0	13680.0	(2320.0)	85.5
2	Бусад орлого	мян.төг	55,978.00	16200.0	8264.5	(7935.5)	51.0
3	Нийт орлого	мян.төг	71,268.00	32200.0	21944.5	(10255.5)	68.2
4	Нийт зардал	мян.төг	37,040.30	26326.0	21187.8	(5138.2)	80.5
5	б) Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	37,040.30	26326.0	21187.8	(5138.2)	80.5
6	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	34,227.70	5874.0	756.7	(5117.3)	12.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, албан шаардлага, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн аудитор Л.Амарзаяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ж.Ням-Осор, захирал Д.Баатарсайхан нар хэрэгжүүлсэн.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Тус байгууллага нь Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журмын дагуу дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд компанийн удирдлагаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй учир төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн болно.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Байгууллага нь дотоод аудитын орон тоо, хэлтэс, тасаг байхгүй учир дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авах дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 21.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.22 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 0.16 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын зорилго нь шинжлэх ухааны дэвшилтэт аргыг мал үржлийн ажил үйлчилгээнд нэвтрүүлж, цөм сүргийн малыг өсгөн үржүүлж, сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан бүс нутгийн хэрэгцээг хангаж ажиллахад оршино. Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот гэж тодорхойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчид аж ахуйн тооцоот статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХТ-ийн 2017 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 11 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлийн 77.1. “Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бүрэн эрхтэй” 77.1.4. “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шйдвэр гаргаж, гүйцэтгэлд хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлагыг Эрдэнэбулган сумын Засаг дарга томилсон байна.

“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасныг хэрэгжүүлээгүй буюу удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоож ажиллаагүй байна. Мөн орон нутгаас төсөв, санхүүгийн дэмжлэггүй зөвхөн өөрийн орлогоор үйл ажиллагааныхаа зардлыг санхүүжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,865.9	416.6	(2,449.3)
Бараа материал	5,964.8	6,464.8	500.0
Үндсэн хөрөнгө	2,822.9	2,202.3	(620.6)
Борлуулах зорилготой биологийн хөрөнгө/мал/	86,019.8	87,712.2	1,692.4
Бусад хөрөнгө биологийн хөрөнгө /эм мал/	176,207.1	177,899.3	(877.5)
Нийт хөрөнгийн дүн	273,880.5	274,695.2	814.7
Өр төлбөрийн дүн	3,374.1	3,432.1	58.0
Богино хугацаат өглөг	3,374.1	3,432.1	58.0
Эздийн өмч	270,506.4	271,263.1	756.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	273,880.5	274,695.2	814.7

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.01 сая, банкны харилцах дансан дахь мөнгөний үлдэгдэл 0.4 сая, нийт 0.41 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Шалгагдагч байгууллага нь төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан , Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд хөрөнгө байршуулаагүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 6.5 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр өссөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2.2 сая төгрөг болж буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгө (борлуулах зорилготой мал) дансны үлдэгдэл 87.7 сая төгрөг болж 1.7 сая төгрөгөөр өссөн нь малын нас дэвшилт төлийн орлоготой холбоотой байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө (борлуулах зорилгогүй эм мал) дансны үлдэгдэл 0.9 сая төгрөгөөр өссөн нь малын нас дэвшилт төлийн орлоготой холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 3.4 сая төгрөг байгаа нь аж ахуй нэгжийн орлогын албан татварын төлөгдөөгүй өрийн үлдэгдэл байна. Харин урт хугацаат өр төлбөр байхгүй.

4.4. ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын 2021 оны “эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 54 дүгээр захирамжаар баталжээ. Энэ төлөвлөгөөгөөр тайлант оны нийт орлогыг 32.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 26.3 сая төгрөгөөр, ашгийг 5.9 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр нийт 21.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 10.3 сая төгрөг буюу 31.8 хувиар, нийт 21.2 сая төгрөгийн зардал гаргаж төлөвлөснөөс 5.1 сая төгрөг буюу 19.5 хувиар, тайлант онд цэвэр ашиг 0.8 сая төгрөг байгаа нь төлөвлөсөн ашгаас 5.1 сая төгрөгөөр тус тус дутуу байна. Үүнд цар тахлын үеийн хөл хориотой холбоотой үйл ажиллагааны сул зогсолтоос болж орлого буурсан нь голлон нөлөөлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна. Энэ хүрээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 61 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 103 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 75 мэдээллийг хугацаандаа байршуулж, 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 11.5 сая төгрөгийн зөрчилд албан 3 албан шаардлага, 2 зөвлөмж өгснөөс, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, шилэн данстай холбоотой 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	-		-		-		
Албан шаардлага	3	11.490.0	2	11.490.0	1		33.4
Зөвлөмж	2		2		-		
Нийт дүн	5	11.490.0	4	11.490.0	1		33.4

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын нийт орлого, зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийг шалгах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй 13.4 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 0.22 сая төгрөгийн материаллаг түвшнээс их байх тул хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

8.1 АЛБАН ШААРДЛАГА

Сар бүр цалингийн зардлын анхан шатны баримт бүрдүүлээгүй, бүртгэл хөтлөөгүй, жилийн эцэст 9.3 сая төгрөгөөр нэг удаа бөөн дүнгээр бүртгэж тайлагнасан байна. Цалин болон түүнтэй холбоотой тооцооны дансуудын бүртгэл хөтлөлт хоорондын төлбөр тооцооны хяналт алдагдаж байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14-р зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг зөрчсөн байх тул албан шаардлага хүргүүлэв.

8.2 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материал худалдан авсан анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй 1.9 сая төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгүүлж баталгаажуулаагүй нь ААНБОАТ тухай хуулийн 13.1.4. бараа, ажил, үйлчилгээний зардал, Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14-р зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" заалтыг тус тус мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид байгууллагатай холбоотой төлбөр тооцооны гүйлгээг татварын цахим системд бүртгүүлж баталгаажуулж хэвших

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллага нь НӨАТ төлөгч бөгөөд тайлант онд НӨАТ шингэсэн борлуулалт хийгээгүй, НӨАТ-ын тайланд 2.2 сая төгрөгийн борлуулалтыг бодитоор илэрхийлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх" гэсэн заалтуудыг дагаж мөрдөж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид байгууллагатай холбоотой төлбөр тооцооны гүйлгээ бүрийг татварын цахим системд бүртгүүлж баталгаажуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ	АРА-2022/224/НА-СТА-ОНӨААТҮГ	Сар бүр цалинтай холбоотой анхан шатны баримт бүрдүүлээгүй, бүртгэл хөтлөөгүй, жилийн эцэст нэг удаа бөөн дүнгээр бүртгэл тооцоо хийж тайлагнасан нь цалин болон түүнтэй холбоотой тооцооны дансуудын бүртгэл хөтлөлт хоорондын төлбөр тооцооны хяналт алдагдаж байна.	ААНБ-д хэрэглэх нбб-ын маягт хөтлөх аргачлал зааврыг хэрэгжүүлээгүй тул Албан шаардлага хүргүүлэх	1	9,251.71					1	9,251.71		
2	Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ	АРА-2022/224/НА-СТА-ОНӨААТҮГ	Бараа материал худалдан авахад анхан шатны баримт бүрдүүлэлт хангалтгүй, E-barimt бүрдүүлээгүй	Анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулах данс бүртгэлд зөв бүртгэх зөвлөмж өгсөн	1	1,970.00							1	1,970.00
3	Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ	АРА-2022/224/НА-СТА-ОНӨААТҮГ	Тус байгууллага нь НӨАТ төлөгч бөгөөд тайлант онд НӨАТ шингэсэн борлуулалт хийгээгүй, НӨАТ-ын тайлан бодитоор илэрхийлээгүй.	Холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, данс бүртгэлд зөв бүртгэж ажиллах зөвлөмж өгсөн	1	2,194.45							1	2,194.45
ДҮН					3	13,416.2	-	-	-	-	1	9,251.71	2	4,164.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ	АРА- 2022/224/НА- СТА- ОНӨААТҮГ	Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах 103 мэдээлэл оруулахаас 28 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна	Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх	1							1		
	ДҮН				1						0			
НИЙТ ДҮН					4	13,416.2	-	-	-	-	1	9,251.71	3	4,164.5